



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/806

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дах заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны хуралдааны III/05 дугаар тогтоол, 2023 оны XVII хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Хүндлэл хамгийн тод гэрэл” жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Аяныг зохион байгуулахад шаардагдах 2,993,900 (хоёр сая есөн зуун ерэн гурван мянга есөн зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян зохион байгуулах ажлын удирдамж, төлөвлөгөөний дагуу шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010959

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын
04 өдрийн А/806 дугаар захирамжийн хавсралт



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ 16 ХОНОГИЙН АЯНЫ
ХҮРЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ “ХҮНДЛЭЛ ХАМГИЙН
ТОД ГЭРЭЛ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Наадаг стикер	40ш	7,800	312,000
2.	Босоо фрейм	2ш	14,400	28,800
3.	Хөндлөн фрейм	2ш	14,400	28,800
4.	Хөөсөн палкат	30ш	7,560	226,800
5.	Тараах материал хэвлүүлэх	300ш	1,600	480,000
6.	Аймгийн жендэрийн статистик товчоон – 2023 оны жилийн эцсийн байдлаар гарган ажлын хэрэгцээнд ашиглах	700ш	2,600	1,820,000
7.	Цагаан тууз (зүүдэг)	150ш	650	97,500
Нийт дүн			2,993,900	

-----oO-----